

**Хүний эш**  
(Төрөлөө зөв нэрлэцгээ)

Доктор /PhD/ Н.Доржготов  
/ГХСС-ийн англи хэлний тэнхмийн багши

Европт үеэлтэйгээ сууж болдгийт кинооос үзлээ. Манайд яагаад болдоггүй юм бэ? гэсэн нэгэн бүсгүйн асуулт миний сэтгэлийг сэргээж буй. Ингээд асуултыг эргэцүүлэн бодлоо. Буруу орчуулгатай кино олон осол бий. Үүнийг судалж буй, судлуулж буй албан байгууллага байхгүй. Судалгаа хийгээд өгөхөд дэмжих дэмжлэг олдохгүй нь ч ойлгомжтой санагдлаа. Манайхан их дуурайдаг хүмүүс. Тэгэхлээр буруу орчуулгыг залруулбал нэг ч боловч хүний цус ойртохыг сэргээж, улмаар удмаа үе үеэр мэдэж байхын чухлыг ойлгоход өчүүхэн төдий тустай хэмээх санаж, элдэв төрлийн шарласан хуудастай, хэдэргэн хэлбэртэй үсэгтэй толь болон эртний судлаачдын зохиолыг хуудаслахыг нь хуудаслаж, уншихыг нь уншвал та бүхэнд толилуулах дорхи зүйл тодорлоо. Монголд ах дүү ойртох нь бүү хэл, азарга нь өөрийн төл байдсаа гишгэдэггүй араншин хэвээрээ л байгаа гэнэ. Азарга нь ийм байхад эзэн нь ямар байж вэ гэсэн асуулт гарна даа. Хэдийгээр өнөөгийн шинжлэх ухааны томъёогоор бичээгүй ч эцгийн эс дийлэх, эхийн эс бага хувь эзэлдэг ч эхийн тээдгийг онцлон ачлал гэж тэмдэглэсэн нь олонтой. Эцгийн эс дийлэнх байдгийг тэр дээр үед манай урдас сайн ойлгосныг Персийн түүхч Раш И Дин: монголын эцгийн үеийг эцэг, өвөг, элэнцэг, будантур, будатур, зүрхэн, дутахун, буданцар гэж тэмдэглэсэн байна. Юрхи гэж буулгасан өнөөгийн бидэнд ойлгогдохдоо хоёрдмол байгаа юм. Зарим зүрхийг юрхи гэж буулгасан бололтой юмаа. Эцгийн үеийг дээрээс нь нэрлэвэл: буданцар, дутахун, зүрхин, өндөр, хуланц, элэнц, өвөг, эцэг, бие гээд есөн үе юм. Хүмүүсийн огт мэдэхгүй болсон нь буданцар, дутахун, зүрхи юм. Буданцар нь будан шиг сарниж, бутарсан санаагаар илэрхийлсэн нь илт байна. Дутахун нь өнөөгийн утгаар холдох гэсэн утгатай үйт нэр байна. Монгол бичгээр ном бичдэг бол утга нь ойлгомжтой. Зүрхийг эртнээс эртний гэсэн утгаар ойлгох явдал байж үүдээ. Иймд биеэс өгсүүлээд нэрлэвэл: бие эцэг /аав/, өвөг, элэнц, хуланц, өндөр зүрхи, дутахун, буданцар болно. Өвөг гэдэг үгийг элэнц, хуланц, өндөр гэсний ард хэрэглэж байна. Энэ байдлыг баримтлаад хэлбэл элэнц өвөг, хуланц өвөг, өндөр өвөг, зүрхи өвөг, дутахун өвөг, буданцар өвөг болно. Эмэг эхийг өвөг адилаар нэрлэсэн байна билээ. Авга аав, авга ээж гэж аавын аав ээж, нагац аав, нагац ээж гэж ээжийн аав, ээжийг нэрлэх ёстой ажээ. Буданцараас улбаатай биеэс есөн үе гарч байна. Үүнийг нэрлэвэл: бие, хүү, ач, жич, гуч, дөч, тач, жилигч, талигч гэсэн байна. Зарим хүн жич гучийн байрлалыг сольж хэлэх нь байна. Жи нь хоёрын, гуч нь гурвын язгуур юм. Тийм учраас гурван настай эр охин малыг гуна, гунж гэдэг. Жи-гийн хоёр гэсэн утгыг хадгалж жидгэр гэж нэрлэдэг. Жидгэр бол нэг эрийн хоёр хүүхэн хоорондоо бие биеэ жидгэр гэдэг. Энд жи-гийн хоёр гэсэн язгуур ойлгомжтой байна. Цаашид бидний зарим нь төөрч буй төрлийн нэр үеэл юм. Үеэлийг хэрэглэх нь мартагдаад, ах дүүгийн хүүхдүүд гэсэн нь олонтаа сонсогдож байдаг. Гэвч орчуулгаар дамжиж үеэлийг сэргээн хэрэглэж эхэлжээ. Олон үг хэлснээс тогтсон нэг үг хэрэглэх нь хялбар бизээ. Төрсөн ах дүүгийн хүүхдүүд хоорондоо үеэл юм. Тэгээд энэ төрлийн хүмүүсийг үеэлид гэдэг. Үеэлид ах, үеэлид охин, үеэлид хүү, үеэлид бэргэн, үеэлид бэр, үеэлид охин, үеэлид хүү гэнэ. Үеэлийн дараах төрлийн үе нь үенцэр болно. Үеэнцэрийн хүйсийг үеэлтэй адилхан хэлдэг байна. Үеэлтэй ижилхэн утгатай бүл гэж үг байна. Бүл бол нэг айлын охидоос гарсан хүүхдүүд буюу, хүү, охиноос гарсан хүүхдүүд хоорондоо бүл юм. Өөрөөр хэлбэл, нэг айлын хүүхдүүдийн хүйсийн ялгааг заасан, хүйс нь эм буюу холимол болчихвол бүл гэдэг ажээ. Үеэл бол дээр нэг эцгийн үр үргэлжилж, бүл нь эм хүйсийг голлон зааж байгаа нь тодорхой утга илэрхийлж байна даа. Үеэлийн дараа ордог чухал төрөл бол авга өвөг, авга, нагацын хүүхдүүдийн төрлийн холбоо байна. Ялангуяа авга, авгын хөвгүүд, ач хөвгүүд үеэлид болдог байна. Авга, нагацын хүүхдүүд бие биендээ хаялид болж, нэг айлын хүүхдүүдийн хүүхдүүд хоорондоо үеэлид буюу бүлүүд болох нь

байна. хаялид бол маш ойрхон төрөл байна шүү. Хаялид ах, хаялид дүү, хаялид ач, хаялид зээ гэх мэтээр нэрлэдэг байна. Хүүгийн хүү ач хүү, хүүгийн охин зээ охин юм. Охиноос гарсан хүү бол зээ хүү, охин бол зээ охин. Ачаас жич гарна. Зарим нутагт ачийг омбул гэдэг. Ачийн хүүхдүүдийг **жич** хүү, жич охин, жич бэр, жич хүргэн, зээгээс гарсан охин зээ охин, хүү нь зээ хүү, зээ бэр, зээ хүргэн болно. Бүсгүй дүүгийн хүүхэд зээ болдог байна. гичээс гуч гарна. Гучид төрсөн хүүхэд биеэс салаалсан дерөв дэх үе ажээ.

Өнөөдөр аавын төрөл, ээжийн төрөл гэж нэрлэх нь сонсдож байна. Гэтэл энэ төрлүүдийг хэдэн зуун жилээр нэрлээд хэвшсэн үгс байна. Аавын талыг авга, ээжийн тал нагац гэдэг. Аавын талыг ярихдаа авга өвөө, авга элэнц өвөө, авга хуланц өвөө буюу нагац өвөө, нагац элэнц өвөө, нагац хуланц өвөө гэх ёстой байна. Мөн аавын ах, аавын дүү гэх нь буруу. Их авга, бага авга, их авга бэргэн, бага авга бэргэн, их нагац, бага нагац, их нагац бэргэн, бага нагац бэргэн гэх нь зөв байна. Авга нагацын хүүхдүүдийг хаялид төрлийн нэрээр авч ярих нь зүйтэй болж байна. Хаялид, үеэлид төрлийн хооронд ойрхон яс угсаа байгаа нь ойлгомжтой. Үеэлид үеэнцэр, хаялид, хаянцар болон садарч, садан гэсэн төрөл үүсч байна. Садангаас аглаг, сунжирга төрлүүд болж холдож байна. Гэхдээ авга талыг нагацаас илүү анхаарч нэрлэсэн нь эцгийн удам хүчтэй салбарладгийг өгүүлж, эцгийн төрөлд цус ойртох улам хялбархныг сануулсан биш үү. Гэхдээ нагац талаас цус амархан холдохгүй байхаа. Бүл ураг нэр дайралдаад байна билээ. Бүл ургийг нарийвчилсныг харсангүй. Худ, ургийн тухайд бол одоохондоо мартагдаагүй байна. Харин гэргий авсанаар нөхөр болно. Анхны нөхөр болон гэргийг авааль нөхөр, авааль гэргий гэж нэрлэдэг байна. Гэргийг авгай, эхнэр мөн зарим газар хатан гэж нэрлэх нь бий. Авгай болно гэдэг нь асар нарийн ёспол үйлдэж, асар үнэ цэнэтэй хувцас өмсгөл бэлдэж бий болдог хүндийн дээд хүндэтгэлтэй нэр. Эхнэр нь нэг эрийн олон эмүүдийг хүүхдүүд нь эх нэр гэж дууддаг байсан нь эхнэр гэж хэлэгдэх болсон баахан шоод утгатай л юм. Хатан бол эм хүнийг хүндлэн дуудах тун сайхан зүйл. Манай Халхад интернационалжин өөрийг умартан ерөөлийг сармагчлан байхдаа феодалын гэж албадан хэрэглүүлэхгүй байна. Уул нь хүний дайтай явваа эр хүнийг ноёнтон, хүний дайтай явваа эм хүнийг хатан буюу хатагтай гэхэд их л хүндэлж буйн шинж тэмдэг мөн болно.

Мөн бичигт аbugai, ярианд гуай хоёр нь нэг утгатай. Аbugai нь бичгийн, гуай нь ярианы үг болохыг ялгаж сурахсандaa. Энэ нь олны хүндийг хүлээсэн эр хүнийг хүндлэн хэлдэг юм. Одоо эмэгтэй хүнийг гуайлж сонсогодох юм. Энэ бол хүний хүйсийг солин хүндлэх бус доромжилж буй хэрэг. Олны хүндийг хүлээсэн эм хүнийг ахай л гэдэг ёстой. Одоо зөвхөн орчуулгын жүжигт хэлж байна. Үдвал ахай, Ганди ахай буюу одоо бол эмч, багш, сэтгүүлч мэтийн мэргэжлийн эрдэмд сайн, алба өөд татаж, үр хүүхдээ зөв төв хүн болгож байгаа эмэгтэйчүүд цөм л ахай гэж хүндлүүлэх бүрэн дүүрэн эрхтэй, ёстой болсон мэт санагдана. Харин засаг захиргааны албаны эрчүүлийг ноён, эмэгтэйчүүдийг хатан гэж хүндэлвэл зүйд илүү нийцнэ. Ноён гэдэг тушаал алга болоод удаж байгаа. Ноён буюу хатан гэж хүндлүүлэх эр ч, эм ч хүмүүс үе үед мэндэлсээр бойжсоор улс орондоо зүтгэсээр байгаа билээ. Нөхрийн дүү гэргийд, гэргийн дүү нөхөрт хүр дүү болдог. Хүр охин дүү, хүр дүү бэр гэдэг. Энэ үгийг мэдэх хүн их л цөөрсөн мэт. Нэг айлын хоёр бэр хоорондоо авсан, ажин болно. Нэг айлын хоёр хүргэн хоорондоо баз болно. Нэг айлын хоёр хүүхэд нөгөө айлын хоёр хүүхэдтэй солбин нийлэх явдал гардаг байна. Ийм болбол андлай худ болно. Нэг эрийн хоёр эм хоорондоо жидгэр, нэг эмийн хоёр эр хоорондоо гуя баз болно. Эхийг төрсөн эх, хойд эх, дараа эх, хадам эх, хөхүүлсэн эх гэнэ. Хойд эх, дараа эх хоёр нэг утгатай байна. мөн хүй тасалж өлгийдэж авсан эмэгтэйг авсан ээж гэдэг. Эрэгтэй хүүхдийг нуган, агь, хөвгүүн гэж хэлдэг. Нуган агт хоёр хүндэтгэлийн утгатай. Хөвгүүн нь жирийн утгатай юм. Хөвгүүнийг ярианд хүү гэдэг байна. Охин хүүхдийг хэүхэн, бяцхан, нунжи охин гэдэг байна. Хэүхэнг хүүхэн гэж дуудаад охин хүүхэд гэхээсээ нас эмэгтэйг ойлгох болжээ. Бусад нутагт хэүхээ гэж дуудаад охин гэсэн утгаар ойлгосон хэвээр байна. Ойрадад бяцхан, буриадад басган гэж байх шиг. Нунж нь жаахан охин тухайлбал, цэцэрлэгт буюу бага ангид сурч буй охин юм. Эрд гараагүй залуухан эмэгтэй ойрадад сээвгэр, буриадад басхан гэдэг бол халхад

хонгор гэдэг байсан нь мартагдаад хайрт хонгор гэж захианд бичихээс цаашгүй болжээ. Хонгор нь монгол аав, ээжтэй, удам сайтай бүсгүй, эрд гараагүй залуухан эмэгтэй хүнийг нэрлэдэг сайхнаас сайхан үг юм. Ноёны охиныг abi, зангийн охиныг bэxi, сайн удамтай охиныг gэgээ гэдэг байжээ. Харин гүнж бол монгол аавтай, манж эхтэй бүсгүй юм. Хүнтэй суугаагүй нас ахисан эмэгтэйг бяцган гэдэг байсан нь Халхад мартагджээ. Гэргий аваагүй нас ахисан эрийг гоонь гэдэг. Одоо гоонь, бяцган хоёр элбэгжих хандлага байна. Ахь жирэмсэлж буй эмэгтэйг ойс гэдэг ажээ. Би өөрт олдсон ном толийг шүүрдэж байж эдгээр зүйлсийг гаргалаа. Тэгэхлээр европынхны сууж болдог үеэл манайхны орчуулсан үеэл хоёрын ялгааг одоо хэлбэл ойлгогдох байхаа. Европт кузен гэдэг үгийг манайхан махчилад үеэл гэж орчуулжээ. Европын кузен нь 1-р үеийн кузен, 2-р үеийн кузен гээд цааш нь кузен гээд үеэл, бүлүүдийг нэрлэдэг юм. Мөн холын саднаа кузен гэнэ. Европын хуулиар бол 4 үе өнгөрснөөс хойших кузенуудыг хоорондоо сууж болно гэсэн бий. Энэ нь яг суух дээр хүрвэл нагац талаас суудаг болохоос авга талаас үгүй юм билээ. Сууж болох кузеныг аглага буюу сунжирга гэдэг холдсон терел дээр хэрэглэдэг үгийн аль нэгээр орчуулбал европ утгаа алдахгүй, монголд цус ойртуулах нүглийг дуудахгүй.

Ноёд, хатагтай нараа гэсэн сонин ч гаргасан харагдсан ба зараар маш их хэлж байна. Энд харьцангуй олны утга илэрхийлсэн д, харьцангуй олны утгыг илэрхийлдэг хар ярианы нар хоёрыг хольжээ. Зүй нь ноёд хатад болбол тэгш хэмнэлийн зарчимд нийцэж яриа, бичгийн хэлний дагавар холихгүй дүрэмд тохирох ёстой болно.

### **”Human tree”(Family tree)**

#### **The summary**

*By N.Dorjgotov*

The Mongolian traditional human tree, and all branches termins are first presented in this article. The author touched the issue because of wrong translation common in movies where the two cousin “were married in that movie”. The author corrected misinterpretation of some European termins and gave the Mongolian equivalents of European names.